

МОНГОЛЫН ХЯТАД СУДЛАЛЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Д.Шүрхүү

*ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн
эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан,
доктор (PhD), дэд профессор*

Монгол-Хятадын харилцаа эдүгээ бүхий л салбар чиглэлийг хамран өндөр түвшинд хүрч хөгжиж буй боловч өмнөд хөршийн эдийн засаг, шинжлэх ухаан-технологи, цэрэг зэвсгийн хүч чадал эрс өсч зузаарахын хэрээр Монгол Улсад хөгжлийн гадаад таатай боломж бүрдэхийн зэрэгцээ их гүрний зах зээл, санхүүгийн цаашдаа улс төрийн хараат байдалд улам бүр гүнзгий лавшран орох аюул занал нэмэгдсээр байна. Нөгөө талаас Монгол Улс жилээс жилд хүчирхэгжин буй өмнөд хөрштэйгээ зөв, зохистой харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх алсын хараатай, ухаалаг бодлого стратегийг боловсруулан амжилттай хэрэгжүүлж чадваас бид хятадын асар том зах зээл, газар зүйн ойр байршил гэх мэт давуу талаа хөгжлийн чухал хүчин зүйл болгож чадна. Эс бөгөөс их гүрний геоэдийн засаг, геополитикийн түрэмгий бодлогод автах, юуны өмнө Монгол дахь хятадын нөлөө байр суурь жилээс жилд нэмэгдэн, энэ орноос эдийн засаг, зах зээл, санхүүгийн хараат байдлын түвшин улам нэмэгдэхэд хүрнэ. Хөрш их гүрнүүдтэй тэнцвэртэй, харилцан ашигтай, алсын хараатай бодлого боловсруулж, хэрэгжүүлэх хөрш орон судлалыг хөгжүүлэх, энэ салбарын эрдэмтэн судлаачдын дорвитой бүтээл, мэргэн зөвлөмж, үнэтэй зөвлөлгөө маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ үүднээс авч үзвэл Монгол Улсад хятад судлалыг эрчимжүүлэх эрэлт хэрэгцээ, шаардлага жилээс жилд нэмэгдэж байна.

Нэг. Монгол дахь Хятад судлалын хөгжлийг эрчимжүүлэх шаардлага

БНХАУ шинэтгэл, нээлттэй бодлого явуулж эхэлсэн 1978 оноос хойш хятадын эдийн засаг өндөр хурдаар тасралтгүй өссөнөөр эдүгээ дэлхийн хоёр дахь том эдийн засаг болж, тус орны улс төр, эдийн засаг, нийгэм, соёл шинжлэх ухаан, батлан хамгаалах зэрэг бүхий л салбарт ихээхэн өөрчлөлт гарсан бөгөөд цаашид ч гарсаар байх төлөвтэй байна. Дөч гаруй жилийн эрчимтэй хөгжлийн үр дүнд Хятадын нийт хүч чадал, дэлхий дахинаа эзлэх байр суурь нөлөө нь ихэд нэмэгдэн хүчирхэгжсэнийг олон улс орон хүлээн зөвшөөрдөг. Гагцхүү энэхүү хүчирхэгжилт

хэр зэрэг удаан, ямар хурдацтай нэмэгдэх вэ гэдэг нэлээд сонирхолтой асуулт урган гардаг, улмаар хятадын эрх баригчид, эрдэмтэд төдийгүй гадаадын тинк танк төвүүд, мэдээлэл дүн шинжилгээний байгууллагууд энэ талын таамаглал, хэтийн төлөвийг идэвхтэй хийсээр байна. Тухайлбал, Их Британий Эдийн засаг, бизнесийн судалгааны төвийн /the Centre for Economics and Business Research, 2020.12/ шинжээчдийн хийсэн судалгаагаар БНХАУ-ын эдийн засаг 2028 онд АНУ-ыг гүйцэж дэлхийн хамгийн том эдийн засаг болно гэсэн дүгнэлт хийсэн тухай Блүүмберг агентлаг дамжуулсан байна. Тэд хятадын эдийн засаг ковид цар тахлын дараах хурдан сэргэн хэвийн голдрилд орох магадлал өндөр байгаа нь өмнөх таамаглалын хугацаагаа 2033 оноос хойш гэж байснаа өөрчлөхөд хүрсэн ажээ. Тус төвийн тооцоолсоноор өмнөд хөршийн эдийн засаг 2021-2025 онд дунджаар 5.7%, 2026-2030 онд 4.5% өсөх бол АНУ-ынх 2021 онд 1.9%, 2022-2024 онд 1.6% өснө хэмээн таамаглажээ. Дэлхийн банкны мэдээгээр 2019 оны байдлаар АНУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүн 21.4 их наяд ам.доллар, Хятадын дотоодын нийт бүтээгдэхүүн 14.3 их наяд ам.доллар байлаа. БНХАУ-ын дарга Ши Жиньпин шинэ таван жилийн төлөвлөгөөнд ирэх 15 жилийн хугацаанд тус орон “орчин үеийн социализм” байгуулах зорилгын хүрээнд эдийн засгаа хоёр дахин өсгөх зорилт бүрэн биелэх боломжтой хэмээн мэдэгдсэнийг Блүүмбергийн мэдээнд мөн дурджээ.

Хятадын эдийн засаг эрчимтэй тэлж буйн өөр нэгэн илрэл бол тус орны дэлхийн хэмжээний том компаниудын тоо сүүлийн жилүүдэд эрс өсөж байгаа явдал юм. АНУ-ын *Forbs* сэтгүүлийн 2020 оны 8 дугаар сард гаргасан *Fortune Global 500* судалгааны тайланд дэлхийн хамгийн том 500 компанийн жагсаалтад багтсан БНХАУ-ын компанийн тоо 124-д хүрч анх удаа АНУ-ын 121 гэсэн үзүүлэлтийг давсан байна. Тайланд хоёр орны дэлхийн 500-д жагссан компаниудын гол гол статистик үзүүлэлтүүдийг жишсэн бөгөөд АНУ-ын 121 том компаний жилийн орлого \$9.8 их наяд хүрсэн бол Хятадын 124 компанийнх \$8.3 их наяд байжээ. Үндсэн хөрөнгийн хувьд Хятадын компаниуд \$36.9 их наяд, АНУ-ынх \$32.7 их наяд байсан бол үр ашгийн хувьд АНУ-ын компаниуд (9.0%) Хятадын компаниудаас (4.5%) илүү байв. Шинжээчид хятадын компаниуд цар хэмжээ далайцаараа хүч түрэн орж ирж буй боловч бодит байдал дээр чадавхийн хувьд тийм ч хүчирхэг биш хэмээн дүгнэсэн байна.¹ Үүний шалтгаан Хятадын 124 компаний 84 буюу 68% төрийн өмчит, тэдгээрээс 54 нь Бээжинд төвтэй нэгдсэн удирдлагатай үндэсний компаниуд² байна. Эдгээр том компаниудын цаана Хятадын засгийн газрын бодлого, санхүүгийн хүчтэй дэмжлэг, төвлөрсөн хатуу хяналт, нийгмийн болон өрийн асар их дарамт, тэр хэмжээгээр үр ашиг ч харьцангуй доогуур байдаг оршино. Хятадын компаниуд үр ашгийн үзүүлэлтээр Канад, АНУ-ын компаниудаас хоёр дахин доогуур байгаа ажээ.

1 *The Biggest But Not the Strongest: China's Place in the Fortune Global 500* August 18, 2020 By Scott Kennedy, <https://www.csis.org/blogs/trustee-china-hand/biggest-not-strongest-chinas-place-fortune-global-500>

2 https://csis-website-prod.s3.amazonaws.com/s3fs-public/200817_TCH%20F500_table_v5.pdf

Хятадын эдийн засгийн өсөлт, хүчирхэгжилт хэр зэрэг үндэс суурьтай, 1.4 тэрбум хүн амд хэр зэрэг хүртээмжтэй вэ гэдэг бас нэг сонирхолтой асуулт байнга гарч ирдэг. БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Кэцян 2020 оны 5 дугаар сард Бүх хятадын ардын төлөөлөгчдийн их хурлын ээлжит чуулган дээр Засгийн газрын 2019 оны тайланг хэлэлцүүлсний дараа болсон хэвлэлийн бага хурал дээр *“Манай улс хүн ам ихтэй хөгжиж буй орон. Хятадын нэг хүнд ногдох жилийн орлого 30 мянган юань байна. Гэхдээ 600 сая орчим хүн дунд болон бага орлоготой, бүр бага орлоготой хэвээр байна. Тэдний сарын орлого дөнгөж 1000 юань буюу Хятадын дундаж хотод өрөө түрээслэхэд хүрэлцэхгүй байна”*¹ хэмээн мэдэгдсэн юм. Энэ үзүүлэлт нэг талаас хятадын нийгэм, эдийн засаг эмзэг, ядуурлын асуудал ноцтой хэвээр байгааг илэрхийлж байгаа бол нөгөө талаас 600 сая хүн амын орлого аажмаар нэмэгдвэл дотоодын асар их эрэлт хэрэгцээ үүсэх магадлал байгааг харуулж, түүнийг дагалдан хятадын зах зээл ч маш их тэлэх потенциал нөөц байгааг харуулж байна.

Хятадын эдийн засгийн хөгжил, зах зээлийн тэлэлтийг тал бүрээс сайтар судлах, танин мэдэх зайлшгүй эрэлт хэрэгцээ хаа сайгүй өсөн нэмэгдэж буй хандлага тодорхой харагдаж байна. Эдүгээ Хятадын эдийн засаг, улс төр, гадаад бодлогыг судалдаг хүрээлэн, тинк-танк төвүүд маш олноороо үүсч, том том төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлж байгаа нь Хятад улс дэлхийн улс төр, эдийн засаг, байгаль орчинд эерэг сөрөг маш их нөлөөтэй, мөн ихээр уялдаа холбоотой, интеграцад их орсонтой, өөрөөр хэлбэл Хятад хямарвал, тэнд тогтворгүй байдал үүсвэл, хүчирхэгжвэл дэлхий, бүс нутаг, тухайн оронд хэрхэн нөлөөлөхийг судлах, хятад судлалыг хөгжүүлэх нь Монгол төдийгүй глобал хэмжээний тулгамдсан асуудал болоод байна. Ялангуяа *Хятадын эдийн засгийн хөгжил, тэлэлт хэр удаан, тогтвортой үргэлжлэх вэ? Тэд энэ их зөрчил, сөргөлдөөн, сорилтыг хэрхэн даван туулж байна вэ? “Хятад загвар” хэр зэрэг амьдрах, татан дагуулах чадвартай вэ?* гэдэг асуултауд хятад судлалын хамгийн сонирхолтой халуун сэдвүүд болоод байна.

Хятадын үе үеийн эрх баригчид бусад орнуудын хөгжлийн туршлага, сургамжийг сайтар судалсаны үндсэн дээр авторитар чанд босоо хяналтыг зах зээлийн тогтолцоотой, нэгдсэн төлөвлөлтийг олон улсын зах зээлтэй зохистойгоор уялдуулж, үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудаа дэлхийн томоохон эдийн засгийн төвүүдтэй нягт интеграцад оруулж чадсанд хятадын тогтвортой хөгжлийн “нууц”, учир шалтгаан оршиж байна.

Хятад хөгжихийн тулд бусдын хөрөнгө, технологи, менежмент авахын тулд тэдний тулгасан дэг журам, тоглоомын дүрмийг хүлцэнгүй дагадаг байсан бол санхүү, эдийн засаг, үйлдвэрлэл, шинжлэх ухаан-технологийн хүч чадал зузаарахын хэрээр өөрийн эрх ашгийг хамгаалсан, их гүрнүүдийн нөлөө, ашиг сонирхол, байр суурийг хязгаарласан дэлхийн улс төр, эдийн засгийн шинэ дэг журам тогтоохыг ихэд чармайх болов.

1 http://english.www.gov.cn/premier/news/202005/29/content_WS5ed058d2c6d0b3f0e9498f21.html

Чухамхүү энэ үүднээс авч үзвэл глобалчлал, чөлөөт, нээлттэй худалдаа, ногоон дэлхийн төлөөх Хятадын идэвхтэй байр суурийг, “Бүс ба зам”, “хүн төрөлхтний нийтлэг хувь заяа” гэх мэт геостратеги, геополитикийн шинжтэй олон санал санаачилгууд, үзэл баримтлалын мөн чанар, зорилгыг илүү сайн ойлгож, таних боломжтой болов уу.

Хятадын дотоод, гадаад бодлогын хувьсал өөрчлөлт дэлхийн их, бага бүх орнуудад янз бүрээр нөлөөлж, харилцан адилгүй хариу үйлдлийг үүсгэж байгаагийн хамгийн тодорхой жишээ бол АНУ-Хятадын зөрөлдөөн, Орос-Хятадын ойртолт юм. Хятад-Европын холбооны хөрөнгө оруулалтын сунжирсан хэлэлцээ, Австрали-Хятадын худалдааны “дайн” ч Хятадын хүч, нөлөөг хазаарлахаас үүдэлтэй. Энэ бүхэн Монгол Улсад, Монгол-Хятадын харилцаанд хэрхэн нөлөөлөх, ямар сорилт авчрахыг нарийвчлан судлах нь тулгамдсан зорилтуудын нэг болж байна.

БНХАУ 2020 онд Монгол-Хятадын харилцаанд ноцтой өөрчлөлт оруулж болзошгүй хоёр том бодлогын стратеги зарласны нэг дэх нь 2035 он гэхэд Хятад улс цөм технологи, инновацийн дэлхийн манлайлагч болох, хоёр дахь нь 2060 онд хүлэмжийн хийг тэглэх тухай зарласан явдал байв.

Хятадын удирдагч Ши Жиньпин 2020 оны 9 дүгээр сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хуралдаанд видео байдлаар оролцох үеэр Хятад улс 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгаруулалт оргил үедээ хүрч, 2060 он гэхэд хүлэмжийн хийг нейтрал түвшинд барихаа амласан мэдэгдэл хийсэн юм.¹ Харин тэр зорилгодоо хэрхэн хүрэх, ямар арга хэмжээ авах, хэдий хэмжээний хөрөнгө оруулалт орох талаар мэдээлэл тодорхойгүй байна. Зарим судлаачид өөрсдийн тооцоо, төсөөллөө дэвшүүлж эхлээд байна. Бээжин дэх Циньхуа их сургуулийн цаг уурын загвар судлаач Жан Шиляны судалгааны төсөөллөөр Хятад улс зорилтоо биелүүлэхийн тулд 2060 он гэхэд цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлээ хоёр дахин, түүний дотор нарны эрчим хүчийг 16 дахин, салхины эрчим хүчийг 9 дахин нэмэгдүүлэх зэрэг сэргээгдэх цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийг асар их хэмжээгээр нэмэгдүүлэх ажээ. Нүүрсээр ажилладаг цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийг орлуулахын тулд цөмийн эрчим хүчийг 6 дахин, усан цахилгаан станцыг хоёр дахин нэмэгдүүлэх шаардлагатай. Кэмбриж дахь Массачусетсийн Технологийн дээд сургуультай хамтран бүтээсэн тус загвар нь засгийн газрын бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн загвар бөгөөд тэдний тооцоогоор хятадын нүүрс хүчлийн хий 2020 онд 9.8 сая тонн, 2025 онд ойролцоогоор 10.3 сая, улмаар 2030 оны үед оргилдоо хүрсний дараа нь 2035 оноос хойш огцом буурч, 2060 он гэхэд цэвэр 0 түвшинд хүрэх ажээ. Гэхдээ ийм богино хугацаанд Хятадын эдийн засгийг малтмал түлшний хараат байдлаас гаргах нь асар их үнэтэй байх болно гэж төслийнхөн үзэж байна. Нүүрсээр ажилладаг эрчим хүч нь тус улсын цахилгаан эрчим хүчний бараг 65 хувийг эзэлдэг бөгөөд шинээр 200 гаруй

¹ Climate change: China aims for 'carbon neutrality by 2060' By Matt McGrath Environment correspondent, 22 September 2020 <https://www.bbc.com/news/science-environment-54256826>

нүүрсээр ажилладаг цахилгаан станц барихаар төлөвлөж байгаа болон баригдаж байна. Иймд тэдний зүгээс “асар их эсэргүүцэлтэй үзүүлэх болно” бололтой.¹

Хятадын өөр нэг судлаач Хэ Жянькуний² үзэж байгаагаар энэ том зорилтонд хүрэхийн тулд 15 их наяд ам.долларын хөрөнгө оруулалт шаардагдах ба сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийн жин 2020 онд 15%, 2030 онд 24%, 2060 онд 84% болж өөрчлөгдөн, 2050 онд нүүрсээр ажилладаг цахилгааны эх үүсвэрээс татгалзах дүр зураг гарсан байна. Профессор Хэ Жянькун Хятадын цахилгаан эрчим хүчний эх сурвалж хүлэмжийн хийг тэглэх үед хэрхэн өөрчлөгдөхийг дор дурдсан байдлаар гаргажээ.

Хятадын эрчим хүчний эх сурвалжийн өөрчлөлт, 2025-2060

ЭХ ҮҮСВЭР	2025	2060	ӨӨРЧЛӨЛТ
Нүүрс	2.86 тэрбум тн.	110 сая	-96%
Байгалийн хий	560 сая	140 сая	-75%
Газрын тос	980 сая	340 сая	-65%
Ус	440 сая	660 сая	+50%
Салхи	240 сая	1.07 тэрбум	+346%
Цөм	170 сая	820 сая	+382%
Нар	150 сая	1.03 тэрбум	+587%

Нэгж-coal equivalent

Өмнөд хөрш нүүрснээс аажмаар татгалзах том зорилт дэвшүүлсэн нь алс хэтдээ Монголын эдийн засаг, экспортын гол бүтээгдэхүүний нэг болоод буй нүүрсний салбарт маш ноцтой нөлөө, ихээхэн сөрөг сөрөл үзүүлэх төлөвтэй байна. Монгол Улс 2019 онд 3 тэрбум ам.долларын үнэ бүхий 36.8 сая тн. нүүрс экспортолсон нь нийт экспортын 40.4% эзлэх болсон нь үүний нотолгоо юм. Эндээс Хятадын эрчим хүч, хүлэмжийн хий, экологийн дипломат бодлого манай хятад судлалын хамгийн чухал сэдвийн нэг болох ёстой гэсэн бас нэгэн үндэслэл гарч ирж байна.

Хоёр. Монгол дахь Хятад судлалын хөгжлийг эрчимжүүлэх арга зам

Монгол Улсад хятад судлалын үндэсний боловсон хүчин бэлтгэх ажил 1980-аад оноос дахин сэргэн хөгжсөн, 1990-ээд оноос БНХАУ-д оюутан улсын болон хувийн зардлаар сургаж эхэлсэнтэй холбогдон зарим шинэлэг зүйлүүд гарч байна.

1 How China could be carbon neutral by mid-century, 19 October 2020 <https://www.nature.com/articles/d41586-020-02927-9>

2 <https://www.bloomberg.com/news/articles/2020-09-28/china-s-top-climate-scientists-lay-out-road-map-to-hit-2060-goal>

Үүнд:

- Юуны өмнө сургалт, судалгааны мэргэжлийн байгууллагын тогтолцоо сайжран, тогтмол санхүүжилт нэмэгдэж, боловсон хүчин, материаллаг баазын хувьд нэлээд бэхжив. ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн /хуучин нэрээр Дорнодахин судлалын хүрээлэн/, МУИС-ийн Хятад судлалын салбараас гадна ШУТИС, МУБИС, ХИС, Их засаг, Отгонтэнгэр, Улаанбаатар, Гэгээ зэрэг улсын болон хувийн олон их, дээд сургуулиудад хятад хэлний орчуулагч, багш, судлаач бэлтгэж байна. Хятад судлалын байгууллагуудын хувьд ч улсын байгууллагаас гадна мэргэшсэн болон олон нийтийн шинэ шинэ бүтцүүд тухайлбал Стратегийн судалгааны хүрээлэн, Аюулгүй байдал судлалын хүрээлэн, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн, Геополитикийн хүрээлэн, Хятад судлалын хөгжлийн хүрээлэн зэрэг үүсч байгуулагдан идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.
- БНХАУ-ын Засгийн газрын болон ӨМӨЗО-ы засгийн ордноос олгодог сургалтын тэтгэлэг жилээс жилд нэмэгдсэн, монголын иргэд хувийн болон компаний зардлаар суралцах явдал нэлээд нэмэгдсэн байна.
- Эрдэм шинжилгээний хурал, гадаад харилцаа ихээхэн нэмэгдэв.
- Хятад судлалд түүх, улс төр, Монгол-хятадын харилцааны түүх, хятад хэл шинжлэл, орчуулга зүй, толь бичгээс гадна сүүлийн үед намтар судлал, аман түүх, хятадын түүх, уран зохиолын орчуулгын чиглэл түлхүү хөгжиж, олон арван ном бүтээл хэвлэгдлээ.

Хэдийгээр Монголын хятад судлалд дээр дурдсан ахиц дэвшил, шинэлэг зүйлс багагүй гарсан боловч өнөөгийн улс, бизнес, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн түвшинд хүртэл хөгжүүлэхэд нэлээд хүндрэл бэрхшээлүүд тулгарсаар байна.

- *Төр засгийн тууштай дэмжлэг сул, санхүүжилт хангалтгүй, санхүүжилтийн эх сурвалж цөөн байна.*

Хятад улс Монголын худалдаа, хөрөнгө оруулалтын хамгийн том түнш, гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн орон төдийгүй Монгол-Хятадын харилцаа нийгмийн бүхий л салбарыг хамран эрчимтэй хөгжихийн зэрэгцээ өмнөд хөршөөс ирэх аюул, тухайлбал эдийн засаг, санхүү, зах зээлийн талаар хэт их хараат байдалд орох, Хятадын улс төр, үзэл суртал, соёл зөөлөн хүчний хүчтэй түрэлт нэмэгдэж буй гэх мэт хятад судлалыг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага өссөөр байхад тухайн чиглэлээр сургалт, судалгаа явуулдаг хүрээлэн, төв, тэнхимийг цомхотгон нийлүүлэх, орон тоог бууруулах хандлага ч гарч байна.

- *Төр засаг, судалгааны байгууллагын харилцан ойлголцол, эргэх холбоо, удирдлага, менежмент хангалтгүй*

Судлаачид дэмжлэг, санхүүжилт бага гэдэг бол төр засаг, бизнесийн хүрээнийхэн судлаачдын бүтээл эрэлт шаардлагыг хангадаггүй, байгууллага, салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо муу байна.

- Боловсон хүчний бодлого алдагдсан, шилжилт хөдөлгөөн, өрсөлдөөн буурсан, англи зэрэг түгээмэл гадаад хэл хятад хэлийг шахах болжээ.

- Нийгэм, улс төрийн сөрөг нөлөө

Улс төр, уламжлалт хятадын их гүрний бодлогоос зай барих, эсэргүүцэх түүхийн сэтгэлгээний улмаас нийгмийн сэтгэл зүйд хятадын эсрэг үзэл амь бөхтэй оршсоор байгаа, зарим тохиолдолд дотоод улс төрийн зөрчил тэмцэл, популизмд хятадын эсрэг үзлийг ашиглан дэвэргэх хандлага нь хятад судлалын хөгжилд тодорхой түвшинд сөрөг нөлөө үзүүлсээр байна.

Хятад судлалыг хөгжүүлэх, түүнд хөрөнгө оруулалт, хүч анхаарлыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага, үндэслэлийг төр засаг, бизнесийн хүрээ, олон нийтэд ойлгуулах, хятад судлалын тэргүүлэх чиглэл, эн тэргүүний зорилтуудаа тодорхойлох хэрэгтэй.

Монгол Улс эрдэс баялаг, газар зүйн байршил зэрэг давуу талууддаа түшиглэн хөгжлөө түргэтгэх арга замыг эрэлхийлж буй өнөө үед хүчирхэгжин өндийж буй БНХАУ нь Монголын хөгжилд нөлөөлөхүйц маш том хүчин зүйл, манай улсын хөгжил, аюулгүй байдал, гадаад зах зээл дэх байр суурийн бэхжилт Хятадтай хэрхэн харьцахаас ихээхэн хамааралтай болоод байгаа учир тухайн оронтой харилцах арга барил, бодлогын үндэслэлийг өндөр түвшинд боловсруулж, шийдвэр гаргах үйл явцад тогтмол ашиглах нь нэн чухал байна. Өөрөөр хэлбэл Хятад судлалыг одоо байгаагаас нь илүү эрчимжүүлж төрийн бодлого, бизнесийн үйл ажиллагаанд илүү ойртуулан, бодлогын хэрэгжилтэд тус дөхөм үзүүлэх шаардлагатай байна.

Монголын нийгэмд Хятадаас болгоомжлох үзэл оршсоор, тэр нь зарим нөхцөлд нийгмийн тодорхой бүлгийн хүрээнд “Хятадын эсрэг үзэл” болон дэврэх хэмжээнд хүрдэг нь хоёр орны найрамдалт харилцаанд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болоод байгаа билээ. Иймээс хоёр улс, үндэстэн харилцан бие биенээ танин мэдэж ойлголцоход дэмжлэг үзүүлэх үүднээс Монголын хүн ард, нийгэмд Хятадын талаарх бодит ойлголт, тодорхой мэдлэг бий болгох нь Монголын хятад судлалын үүрэг болно. Монгол дахь хятад судлалыг эрчимжүүлэн хөгжүүлэхийн тулд:

- Юуны өмнө Хятад судлал эрхлэн буй сургалт, судалгааны байгууллагууд ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагаа, дагнан мэргэших асуудлаа хэлэлцэн зохицуулах нь цаг хугацаа, хөрөнгө, хөдөлмөр хэмнэх, тодорхой чиглэлд хүн анхаарлаа төвлөрүүлэн илүү үр дүнд хүрэх боломжийг нээнэ.
- Судалгааны эх үүсвэр олох, дотоод гадаад түнш олж авахад шинэлэг арга барил, сэтгэлгээ, орчин үеийн менежментийг ашигламаар байна. Нэг жишээ бол *China Observers in Central and Eastern Europe (CHOICE)* хэмээх Төв ба Зүүн Европын орнуудын шинжээч, судлаач, мэргэжилтнүүдийн консорциум. Тус бүсэд өсөн нэмэгдэж БНХАУ-ын нөлөө, байр суурийн талаарх судалгаа явуулах зорилготой уг шинэ бүтэц нь Төв, Зүүн Европ дахь Хятадын бодлого, үйл ажиллагаанд ажиглалт, дүн шинжилгээ хийх, мэдээлэл солилцох, хэлэлцүүлэг явуулах чухал талбар болж байна.

- Хятад судлалын боловсон хүчнийг системтэй, бодлогоор бэлтгэх, академич Ч.Далай, Н.Ишжамц, доктор Л.Жамсран, Г.Сүхбаатар, Чой.Лувсанжав зэрэг нэртэй хятад судлаачдын эрдэм судлалыг залгамжлан хийх залуу үеийг бэлтгэх хэрэгтэй байна. Сургалтын чанар судалгааны арга зүй, оюуны хөдөлмөрийн үнэлгээг шинэ шатанд гаргах шаардлагатай.

ТОВЧ ДҮГНЭЛТ

Хятад орон хувьсан өөрчлөгдөж, дэвжин хүчирхэгжиж буй нь дэлхий нийт, түүний дотор хөрш Монголын анхаарлыг зүй ёсоор татаж байна.

Эдийн засгийн хувьд тэлэхийн хэрээр Хятадын дотоод, гадаад бодлого, геостратеги ч даган өөрчлөгдөж, өөрийн үндэсний эрх ашгаа хамгаалах өнцгөөс дэлхийн дэг журмыг өөрчлөхийг эрмэлзэж, үүний тулд янз бүрийн санал санаачилгууд дэвшүүлж байгаагийн нэг хэлбэр бол “Бүс ба зам” санаачилга.

Өмнөд хөрш хувьсан хүчирхэгжиж, түүний нөлөө, бодлого, стратеги өөрчлөгдөж байгаа нь Монголын хятад судлалыг хөгжүүлэн эрчимжүүлэх зайлшгүй шаардлага нөхцлийг бүрдүүлж байна. Үүний тулд хятад судлалыг тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, байгууллага, салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг идэвхжүүлэн, санхүүжилт, боловсон хүчний бодлогоо чамбайруулан, судалгааны үр дүнг төрийн бодлого, бизнесийн үйл ажиллагаанд ашиглах зохистой механизм, үнэлгээ мониторингийн тогтолцоог сайжруулах хэрэгтэй байна.